

Сэлэнгэ сумын Цэцэрлэгт төлөвлөгөөт
хяналт шалгалт хийсэн тухай

Хяналт шалгалтын зорилго

Санхүүгийн хяналт аудитын албаны 2017 оны хяналт шалгалтын нэгдсэн төлөвлөгөө, аймгийн Засаг даргын баталсан 2017 оны 09 сарын 25-ны 1/18 дугаар удирдамжийн дагуу санхүү, төсөв, нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон бусад холбогдох дүрэм, журам, тушаалуудын хэрэгжилтийг хангуулах, үндсэн үйл ажиллагааны байдал, зохион байгуулалт, өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, зарцуулалт, санхүүгийн үйл ажиллагааны байдлыг шалгаж, үнэлэлт дүгнэлт өгөх, ололт амжилтыг бататгаж, зөрчил дутагдлыг арилгахад оршино.

Хяналт шалгалтын бүрэлдэхүүн, албан тушаал, хугацаа

Санхүүгийн хяналт шалгалтын улсын ахлах байцаагч Б.Баттулга
2017 оны 09 дүгээр сарын 26-аас ажлын 6 хоног

Шалгалтанд хамрагдсан байгууллага, объектын нэр

Сэлэнгэ сумын Улсын тэргүүний “Ундраа”Цэцэрлэгийн 2016 оны санхүү, аж ахуйн үйл ажиллагаа хамрагдав.

Шалгалтанд хамрагдсан объектын талаарх товч мэдээлэл

Булган аймгийн Сэлэнгэ сумын Улсын тэргүүний “Ундраа” цэцэрлэг нь эрхлэгч 1, арга зүйч 1, бүлгийн багш 7, туслах багш 7, дуу хөгжмийн багш 1, нярав 1, тогооч 5, галч 7, үйлчлэгч 1, сахиул 1 нийт 32 орон тоотойгоор үйл ажиллагаагаа явуулж ирсэн байна.

2016 оны 01 сарын 01-нээс 2016 оны 12 сарын 31-ний өдрийг хүртэл 1-р гарын үсгийг дарга Д.Наранчимэг, 2016 оны 01 сарын 01-нээс 2016 оны 12 сарын 31-ний өдрийг хүртэл 2-р гарын үсгийг нягтлан бодогч М.Энхбат, нар тус тус зурсан ба төрийн санд бүртгэлийн 040915201 тоот данстайгаар орлого, зарлагын гүйлгээг хийж, хөрөнгө мөнгийг захиран зарцуулж иржээ.

Нягтлан бодох бүртгэлийг санхүүгийн тооцоолох “CTS” программаар бүртгэж хөтөлсөн байна.

Өмнөх шалгалтын талаар

Сэлэнгэ сумын Улсын тэргүүний “Ундраа” цэцэрлэгийн 2016 оны санхүү аж ахуйн үйл ажиллагаанд бусад байгууллагаас хяналт шалгалт хийгдээгүй болно.

Шалгалтын явцад хийгдсэн ажил, шийдвэрлэсэн асуудал

Тус цэцэрлэгийн 2016 оны касс, харилцахын баримт, няравын тайлан, нягтлан бодох бүртгэлийн журнал, эрхлэгчийн тушаал, цалингийн карт, цалин олгох хүснэгт, нийгмийн даатгалын болон татварын, санхүүгийн тайлан, 2016 оны санхүүгийн тайлан зэрэг баримт материалуудад тулгуурлан эрхлэгч Д.Наранчимэг, нягтлан бодогч М.Энхбат, нярав Ж.Амаржаргал нарыг байлцуулан төлөвлөгөөт хяналт шалгалтыг хийлээ.

Санхүүжилт, орлогын талаар: /мянган төгрөг/

2016 онд төсвөөс 366348.7 мянган төгрөгийн санхүүжилт авахаар төлөвлөж, гүйцэтгэлээр 366348.7 мянган төгрөгийг авч, нийгмийн даатгалын сангаас жирэмсэн амаржсаны тэтгэмж 2 хүний нийт 6507.5 мянган төгрөг нийт 372856.2 мянган төгрөгийн эх үүсвэртэй ажилласан байна.

Төсөвт зардлын талаар /мян.төг/

2016 онд төсөвт зардлыг 366348.7 мянган төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэлээр 366348.7 мянган төгрөгийг зарцуулсан байна. Ажилчдын цалинд 183225.2 мянган төгрөг, нэмэгдэл цалинд 13634.1 мянган төгрөг, урамшуулалт цалинд 19196.4 мянган төгрөг, гэрээтийн цалинд 18425.7 мянган төгрөг, ндш-д 25793 мянган төгрөг, тогтмол зардалд 35228.5 мянган төгрөг, хангамжийн бараа материалд 9629.4 мянган төгрөг, нормативт зардал буюу эм, хоол хүнс 47616.5 мянган төгрөг, нормын хувцас зөөлөн эдлэл болон урсгал зардалд 4179.1 мянган төгрөг, томилолт 175.8 мянган төгрөг, хичээл үйлдвэрлэлийн дадлага 2610.3 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардалд 595.7 мянган төгрөг, нэг удаагийн тэтгэмж урамшуулалд 231.9 мянган төгрөг тус тус зарцуулсан байна.

Цэцэрлэгийн эрхлэгчийн 2016 оны 03 сарын 18-ны өдрийн Б/14 дугаартай тушаалаар 22 ажилтанд 2517.7 мянган төгрөгийн, 2016 оны 06 сарын 20-ны өдрийн Б/26 дугаартай тушаалаар 27 ажилтанд 3980.5 мянган төгрөгийн, 2016 оны 09 сарын 26-ны өдрийн Б/35 дугаартай тушаалаар 24 ажилтанд 1876.4 мянган төгрөгийн, 2016 оны 12 сарын 13-ны өдрийн Б/43 дугаартай тушаалаар 23 ажилтанд 4202.4 мянган төгрөгийн нийт 12577.0 мянган төгрөгийн үр дүнгийн урамшуулалт цалин олгосон байна.

Үндсэн хөрөнгө, бараа материалын тайлангаар:

2015 оны үндсэн хөрөнгийн эхний үлдэгдэл 259814.6 мянган төгрөг дээр орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар 36 ш хүүхдийн ор 2160.0 мянган төгрөгийн, зургийн аппарат 1900.0 мянган төгрөгийн, махны машин 1490.0 мянган төгрөгийн, 4 ширэмтэй пийшин 4450.0 мянган төгрөгийн нийт 10000.0 мянган төгрөгийн хөрөнгийг шилжүүлэн үндсэн хөрөнгөнд бүртгэж, 269814.6 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийн үлдэгдэлтэй байна.

Бараа материалын эхний үлдэгдэл 47529.9 мянган төгрөг дээр бичиг хэрэг 935.8 мянган төгрөг, аж ахуйн материал 3082.4 мянган төгрөг, түлш, шатах тослох материал 21316.8 мянган төгрөг, хүнсний материал 58722.2 мянган төгрөг нийт 84057.3 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, 83001.4 мянган төгрөгийн материалыг үйл ажиллагаандаа зарцуулж оны эцэст 48585.8 мянган төгрөгийн үлдэгдэлтэй тайлан гарсан байна.

